

МОНГОЛ, ТУВА БИЧГИЙН ХЭЛНИЙ ДУНДЫН ҮГИЙН
БҮТЭЭВРИЙН ТОХИРОЛ

Д.Баасанбат

Түлхүүр үг: бүтээвэр, хувьсал, тохирол, сэлгэц, тонгорол, хувилбар

Монгол, тува бичгийн хэлний дундын үгийн зарим бүдэг бадаг зүйлийг тодруулан сэргээх, хэлний хувьслын дүнд гарсан өөрчлөлт зэргийг судлахад нэгэнт хэл шинжлэлийн шалгарсан арга болох уламжлалт түүхэн харьцууллын аргыг голлон, бүтэц зүйн дахин сэргээх аргыг ашиглан хоёр хэлний бичгийн хэлний 2000 орчим дундын үгийг картлан бэлтгэж зэрэгцүүлэн задлан шинжилж, дундын үгийн авиалбарын сэлгэц, тонгорол, зэрэгцэл, ижил ба ойролцоо бүтээврүүдийг харьцуулан авч үзлээ. Сэлгэцийн талаар эрдэмтдийн үзэл баримтлал нь:

И.А.Бодуэн де Куртенэ сэлгэврийг (альтернаци) 4 ангилсан. Үүнд:

а. “и” авианы өмнөх гийгүүлэгч тагнайшин зөөлөрч хэлэгдэхийг зэрэгцэн нөлөөлөх (когеренция),

б. өргөлт зэргээс шалтгаалан “воды, вода, вьд аной” гэж “о” авиа нь “о” ,”ь” болон хувирахыг зэрэгцэн салаалах (дивергенция),

в. “ходит-хоживать” гэхэд “д” авиа нь “ж” авиагаар сэлгэж төгс, эс төгс байдал заасныг тохицон сэлгэх (корреляция),

г. анхны язгуурын “о” нь “а” болон хоосонтой сэлгэснийг төлөөлөх (корреспонденция) сэлгэц гэжээ. Үүнээс үзвэл, авиа сэлгэх ёсыг утгад нөлөөлөх, эс нөлөөлөхийг харгалзан когерент-дивергент-коррелятив-корреспондент гэж шатлан нэрлэж ангилжээ.

Р.И.Аванесов “бол-боль” гэх үгийн өргөлтөт үеийн тагнайшсан ба эс тагнайшсан “о” авиаг ижилссэн сэлгэц (параллельное чередование), “бхат-багтах” гэдгийн сул байранд буй хамжих “г” нь шүргэх “х” болсныг ондоошсон сэлгэц (непараллельное чередование) гэж авиалбарын хувилбарыг 2 ангилжээ.

А.А.Реформатский “друг-друк, лобный-лоп” зэргийн сэлгэцийг авианы гээд, “пустит-пуцу, сухой-суще, могу-мочь, собратъ-собирает, морозит-мораживал” зэрэг сэлгэцийг авианы бус гэж ангилсан байна.

Т.А.Бертагаев монгол хэлний авиа сэлгэх нь үг бүтээх нэг чухал арга гэж үзээд “агсам, огсом, огцом, агших, огших, огт, огтлох, агт, агтлах, эгц эгцлэх, аглуун, аг барих, агзайх, эгших” зэрэг үгийн “аг, ог, эг” язгуур нь эгшиг сэлгэж үүссэн ба, “уг, иг (ээрүүлийн)” зэрэг үг ч дээрх үгээс авиа сэлгэж үүссэн гэжээ. Тэрбээр

Цуваа цаг

Хам цаг

агталаку-огтулаку

хавдах-хавсах

багча-богча,

шовх-шөвх

тангнаку-чингнаку

гөлийх-голийх-гилийх...

г.м үгийн язгуурын сэлгэцээр,

кагара-кагала	ихсэх-ихдэх
талк-а-талки	багачуул-багачууд
донггудку-донггуску	буржийх-бурзайх
	борооноор-бороогоор...
г.м бүтээврийн утгалбараар,	
модуйику-моудуйику	жин-нэ- жигнэ
(модойх-моодойх)	хүртэл-гүртэр
омугураку-обугараку	хашаа-гашаа
(омоорох-омоорох)	бадаг-бадак...
г.м. язгуур бүтээврээр,	
сүрсигүл-сүрсигүр	зурмал-өрмөл
комнаку-комлаку	ээрмэл-зормол...
г.м дагаврын илэрхийлбэрээр,	
нисугай-нисукай....	чийкү-чайику
амсгай-эмсгий	чачаг-чэчэг
ховил-говил	дүрим-жирум
ай-үй...	
г.м үгийн үндсийн агуулбараар,	
-йин (харь.т.я)	-ийн, -ын (малын)
-йи Ш (заах.т.я)	-ий Ш, -ы Ш нь (малы нь)
	- Ш, (нохойн Ш)
	-ны, (нохойны...)
г.м нөхцөл ба хоосон гишүүлбэрээр,	
эбүл-өбүл-өвөл-өвөл	битүү-бүтүү
сируй-шируй-шоруй-шороо	шаргуу –шургуу
	завшаан-жавшаан
	чагт-чахт...
г.м. нэрлэвэр үндэс гишүүлбэрээр,	
-йин, -йи	-аасай
-ун, -ын	-оосой (өөрийгөө)
-үн, -йин	-ээсэй, өөсэй (өөрийгээ)...
г.м нэрлэвэр нөхцөл гишүүлбэрээр сэлгэж байна гэж дурдсан юм.	

В.И.Золхоев сэлгэврийг хам цагийн үүднээс судалж “явав-яф, цэцэк-цэцгээр, залуучуут-залуучуудаар” г.м. хувилбарыг харьцуулж “в-ф, к-г, д-т” зэрэг сэлгэвэр байдгийг тодорхойлсон байна. Эдгээр нь авианы болоод бүтээврийн байрлалаас шалтгаалан үүсэх ажээ. Жишээ нь: хошуу-хушуу, зарчим-жарчим-жарчам, соруул-суруул.

Хам цагийн үүднээс монгол хэлний авианы сэлгэцийг

1. дан авианы найруулгын холбогдолтой “эрүү-үрүү, билүү-бүлүү, хашаа-гашаа-ашаа, ажил-ажал”,
2. авианы болон утгын найруулгын холбогдолтой “мээм-мөөм, ханшаар-хоншоор, өд-сөд, төвшин-түвшин, ховил-говил, чийрэг-чаараг, болор-молор, гэм-зэм”.
3. утгын болон авианы найруулгын холбогдолтой “сартгар-сэргтгэр-сортгор-сөртгөр, хангинах-хонгинох-хүнгэнэх-хөнгөнөх-хэнгэнэх”,

4. дан утгын найруулгын холбогдолтой “давших-дэвших, цоорох-цуурах, царгих-цоргих, тургих-дургих”... г.м. гэсэн бол, Ж.Санжаа нэг фонемийн хувилбарууд үүргээрээ харилцан бие биеэ нөхдөг шиг өөр фонемууд ч бас үүргийнхээ талаар харилцан бие биеэ нөхнө... гэх мэтээр эрдэмтэд өөр өөрийн дүгнэлт хийсэн байна.

Алтай хэлний салбар аялгуунуудыг зэрэгцүүлж, харьцуулж судлахад төрөл хэлний гийгүүлэгч хоорондын сэлгэлт онцгой анхаарал татна. Жишээ нь:

Монгол хэлний “дурд” гэсэн үйл язгуур үндсэнд, үйлдүүлэх хэвийн нөхцөл залгавал “дуртга” гэж “д” нь “т” болон ондоошно. Мөн “д” нь “с” авиатай сэлгэн “дурсгал” гэдэг бие даасан үг үүсгэнэ. Ийнхүү “д” нь “т” авиатай сэлгэвэл бүтээврийн хэлбэрийн хувилбар, “д” нь “с” авиатай сэлгэвэл бие даасан бүтээврийг үүсгэж байна.

Гийгүүлэгч авианы ялгарах шинжийн тогтолцоог шуугиант, сонсголонт гийгүүлэгчийн эсрэгцлийн ялгарах шинжээр, бүтэх байрын эсрэгцлийн ялгарах шинжээр, эс тагнайшсан, тагнайшсаны эсрэгцлээр харьцуулж гаргах нь чухал байна.

Монгол хэлний шуугиант гийгүүлэгчийн хэл болон уруулын эсрэгцэл нь нийт монгол хэл аялгуунд биеэ даасан авиалбар мөн эсэхийг батлах тогтвортой ялгарах шинж болдог. Уруулын гийгүүлэгч уруулын гийгүүлэгчтэй, хэлний гийгүүлэгч хэлний гийгүүлэгчтэй сэлгэдэг нь түгээмэл зүй тогтол. Авианы хэлэх, сонсох утга ялгах сул байранд, авиа зүйн түвшинд шуугиант, сонсголонт гийгүүлэгч зэрэгцсэн бусаар сэлгэх, шуугиант гийгүүлэгч уруулын ба хэлний гийгүүлэгч бүтэх аргаар зэрэгцсэн бусаар сэлгэх, эс тагнайшсан болон тагнайшсан гийгүүлэгч авиа зэрэгцсэн бусаар сэлгэх, авиа ижилсэх, ондооших, төсөөрөх, анирших, байраар болон тагнайшилтаар гийгүүлэгч авиа сэлгэдэг.

Гол ба гол бус аялгууны ялгаа бүхий “халх-галх-, талх-далх, нохой-нокаа, хагас-хагад” г.м. сэлгэц байхаас гадна хүүхэд залуус ба ахмад үеийнхний ялгаж хэлэлцдэг “чийрэг-чаараг, торних-тарних, халцлах-холцлох-хулцлах, за-жа, бяцхан-бичхэн, нулимс-нилбус...” гэх мэт сэлгэц байна.

Авианы хувьсал нь монгол бичгийн хийгээд бусад дурсгал бичигт зохих хэмжээгээр туссан байдаг. Жишээ нь: “амискал-амискул, эчигэ-эчэгэ, танггариг-танггараг, көрүг-көриг, умартаку-мартаку” г.м.

Фонемийн ялгах үүрэг нь авианы эсрэгцлээр, бүтээх буюу нийлэх тал нь авианы сэлгэцээр илэрнэ. Энэ хоёрыг салгаж болохгүй. Иймээс ялгаруулах шинжээс нь сэлгэцийн зүй тогтлыг мэдэж болно.

Чанга сул гийгүүлэгчийн харилцан нөлөөлөл, зөвхөн нэг хоёрдугаар үед төдийгүй, хоёр гуравдугаар үед ч байдаг. Мөн авиа саармагших ёс, чанга сул фонемын дундын саармагшсан авиа болох гиперфонемын хувилбарууд хаана хаана байгааг илрүүлэх нь чухал. Иймийн тулд эрдэмтэд,

- Ийм сэлгэмэл хувилбар нь утга ялгах чадвар буурсан буюу эсвэл утга ялгахгүй болсон байдаг гэж Москвагийн авиа зүйчид үзэх,
- Гийгүүлэгч гээгдэх үзэгдлийг авиалбарын тэг хувилбар гэж үзэх,
- Авиа нь ондоошсон буюу ижилссэн сэлгэцээр хувилбар, авиа хоёрыг ялгаж, сэлгэврийг олон монгол хэлний жишээгээр тайлбарлах,
- Хэлний авиа сэлгэх ерөнхий тогтолцооны дотроос хэлэх үйл ажиллагааг хөнгөвчлөх үүрэгтэй авианы нөлөөлөн хувьсах сэлгэцийг тайлбарлах,
- Утга ялгах буюу үг бүтээх сэлгэлт, нөлөөлөн хувьсах сэлгэлт хоёрыг ялгаж үзэх,
- Авианы эсрэгцэл ялгарах шинж болохыг тодорхойлох,
- Хэлний тогтолцоог буй болгодог фонемийг олж тогтоох,
- Хэлэхэд илэрч байгаа фонемийн олон хувилбар, тэдгээрийн сэлгэцийг амьд хэл аялгууны

баялаг хэрэглэгдэхүүн дотроос илрүүлэн таних, авианы хуулиар нотлон тайлбарлах... нь чухал гэж үздэг. Үүний учир шалтгаан нь нийгмийн хөгжил дэх хэл аялгууны одоогийн нөхцөл байдал, мөн хэл аялгууны дотоод зүй тогтлыг, авианы хуулиар тайлбарласан байдаг.

Алтай язгуурын хэлийг судлахад салбар аялгуунуудыг харьцуулан судлах хэрэгтэй. Төрөл хэлийг зэрэгцүүлэн судлахад чухал зүйл бол гийгүүлэгч хоорондын сэлгэлт юм. Ийм үзэгдэл монгол, тува хэлний дундын үгэнд нэлээд байна. Иймээс, монгол, тува хэлэнд:

1. Тува хэлэнд үеийн тоогоор ойролцоо монгол хэлний зэрэгцэл байна. Харин цөөн үетэй үгс нь түрэг хэлний үгийн санд илүү ойр байна. Жишээ нь: Тува хэлний “шингээ” гэдэг үгийн үндэс “син-” нь эртний түрэг хэлний “син-”, мон бич: “син”, монг: “шин”... гэх мэт.

тув: “күш” “хүч тамир”, эрт түр: күч ба кұьчү- “хүч чадал”, мон бич: хүчүн, монг: хүч- “хүч тамир, хүч чадал”... гэх мэт.

2. Монгол, тува хэлэнд бүх байж болох холбоо, хоршоо үгийн хоёрдугаар гишүүн болох үгс нь монгол хэлнээс гарал үүсэлтэй байна. Монгол болон түрэг хэлэнд иймэрхүү маягтай холбогдсон тува хэлний үгс монгол хэлний зохицож байгаа үгсийг бодвол илүү богино болж байгаа үг нь түрэг хэлнийх болдог. Жишээ нь:

тув: аяк “аяга”, эрт түр: “айак”, мон бич: “айаг-а”, монг: “аяга”,

тув: “саа”-, эрт түр: “sag”, мон бич: “сага”, монг: “саа-” гэх мэт.

3. Монгол, тува хэлний нэгдүгээр үеэс хойших “р” гийгүүлэгчтэй үг түрэг хэлний исгэрэх гийгүүлэгч авиа [p]-тэй сэлгэсэн гийгүүлэгч “-с, -з”-тэй үгс тохирч байна.

мон. бич:

эрт. түр:

тув:

бору

бос

бора

кураган

козы

хураган

үкэр

өкүз

үьгер

4. Зарим тохиолдолд түрэг, монгол хэлний хэлбэр ижил байна.

мон. бич:

эрт. түр:

тув:

монг:

ура/н/ уз, ус, “уран, хашир, чадамгай, ус “уран чадамгай” ура “чадамгай, заль мэх”.

5. Монгол хэлний үг бүтээх зарим залгавар бүтээврийг тува хэлний жинхэнэ үг бүтээхэд хуулбарлан болон зээлэн ашиглаж байсан нь ХХ зууны 30-аад оноос эхлэлтэй тувагийн утга зохиолын хэл үүсэхэд ихээхэн нөлөөлсөн юм. Утга зохиолын хэл ба аман аялгуунд ийм хэлбэрүүд нь бие биедээ сэлгэж байдаг. Үүнийг монгол хэлний тува хэлэнд зээлдэн оруулсан маш олон бүлэг үгсийг авиазүй-үгзүйн шинж тэмдгүүдээр нь ажигласнаар олж болно. Давтагдаж байгаа монгол язгуурын үгсийн авианы төлөв нь үүсгэвэр хэлний үг бүтээврийн гишүүн, тэдгээртэй дүйцэхүйц шинжтэй байгаа нь бүр ч эргэлзээгүй болгож байна. Ингэж зээлдэн хэрэглэсэн залгаврууд үүргээрээ бие биетэйгээ ихээхэн ойролцоо ба хийсвэр, цөөн тооны тодорхой, ихэвчлэн үгсийн заасан юмны утгатай үгсээс үйл үг бүтээхэд ашигладаг байжээ. Түүнд -л, -лга, -лда, -мал, -мча... зэрэг залгаврууд орно. Эдгээр залгаврыг дуудагдах авианы төлөв, тува болон монгол хэлэн дэх утгууд нь дүйцэхүйц байж чадвал монгол хэлнээс зээлдсэн үгс гэж тодорхойлж болох юм.

- Монгол хэлнээс зээлдсэн үгс дотор үйлээс нэр үг үүсгэх -л залгавар идэвхтэй хэрэглэсэн нь их тааралдана. Жишээ нь:

тув: авырал “өршөөл аврал”

мон. бич: абурал

монг.: аврал

тув: айыткал “илтгэмж, илтгэл”

мон. бич: айиладкал

монг.: айлтгал

тув: айыыл “аюул осол”

мон. бич: айул

монг.: аюул, занал

тув: амыдырал “амьдрал”

мон. бич: амидурал

монг.: амьдрал

тув: белеткел “бэлтгэл”

мон. бич: бэлэдкэл

монг.: бэлтгэл

тув: иьдегел “итгэл найдвар”

мон. бич: “итэгэл”

монг.: итгэл

- Тува хэлний -лга, -лда дагавар нь хоорондоо ойролцоо бөгөөд, монгол бичгийн -лта ба -лага дагавартай тохирдог. Жишээ нь:

тув: <i>байысаалга</i> “байцаалга”,	монг: <i>байцаалга</i>
тув: <i>бодалга</i> “үүрэг зорилго”,	монг: <i>бодлого</i>
тув: <i>дуржжуга</i> “туршилга”,	мон. бич: <i>турсилг-а</i> ,
тув: <i>карылга</i> “гарз, гарлага”,	мон. бич: <i>гарулг-а</i> ,
тув: <i>капсырылга</i> “хавсралт”,	мон. бич: <i>кабсуралг-а</i>
тув: <i>шөлүлгэ</i> “цөллөг”,	мон. бич: <i>чөлүлгэ</i>
тув: <i>немелде</i> “нэмэх, хавсрах”,	мон. бич: <i>нэмэлтэ</i>
тув: <i>сонгулда</i> “сонгох”,	мон. бич: <i>сонггулта</i>
тув: <i>шылгалда</i> “шалгалт”,	мон. бич: <i>силгалта</i>

- Мөн үйл үгээс зээлдэн авсан -гда хэлбэртэй үйлдэгдэх хэвийн хэлбэрээс олноор хадгалагдсан нь байна.

тув: *боогда*- “хаах, боох”, мон. бич: “*богогда*”, монг: *боогд* “саад, тотгор, бэрхшээл, төвөг учрах, зогсох байх, саад тотгортой учрах, хэцүү газар байрлах”, мөн *боо*- “хаан хориглох, хаах боох, саад хийх”,

тув: *качыгда* “зовох, өвчтэй байх”, мон бич: *качигда* “хавчигдах” *качи*- “дарамтлав, дараас болох, хавчих”. монг: *гачигд* “дутагдах”,

тув: *соругда*- “зорилго тавих, зорих тэмүүлэх, чармайх, авахыг хичээх”, монг: “*зоригда*”- зорь гэсэн үйл үгийн үйлдэгдэх хэвийн хэлбэртэй болсон зорих, тэмүүлэх, зорилгоо төлөвлөх, зорилготой байх”.

Дээрх жишээнээс харахад тува хэлний зээлсэн үг нь өөрийнхөө утгаар бусдаар үйлдүүлэх хэвийн хэлбэрт болон анхныхаа хэлбэрт байгаа юм шиг монгол хэлний үйл үгтэй ойролцоо байж болно. Цөөнгүй тохиолдолд хоёр хэлний хэлбэрт хоёуланд нь зээлддэг, гэвч утгазүйн ялгаа нь эн зэрэгцээ хоёр хэлний хооронд зээлэгдэхгүй. Жишээ нь: Зээлэгдсэн үгсээс,

тув: *дурда* ба *дурдагда* “хүрэхгүй, дутагдах”, мон. бич: “*дута*” монг: *дут*-

тув: *түре*- ба *түрегде*- “ядах зүдэх, гуйланчлал, зовох, тарчлах, өвчтэй байх”, мон бич: “*түрэ*- *түрэгдэ*”, гачигдал зовлон ядуурах, үгүйрэх”,

тув: *үре*- ба *үрегде* “зүсэх, хэрчих, эвдэх, буулгах, нураах”, мон бич: *үрэ*- “үрэх цацах, тарааж хаях сацах, зарцуулах, зарах, гарздах, үрэх зарах, утгах үгүй хийх, хөнөөх үхүүлэх”, мон бич: *үрэгдэ*- “хөнөөгдсөн байх, үгүйрүүлэх, хоосруулах, зовлон эдлэх, устгагдах”... г.м.

- Зээлдсэн үгс дотор -мал залгавартай үгс харьцангуй цөөн тааралддаг. Жишээ нь:

тув: <i>бийжжимел</i> “гар бичмэл”	мон. бич: <i>бичимэл</i>	монг: <i>бичмэл</i>
тув: <i>доктаамал</i> “байнгын”	мон. бич: <i>токтамал</i>	монг: <i>тогтмол</i>
тув: <i>чурумал</i> “дүрслэл, хээ”	мон. бич: <i>жирумал</i>	монг: <i>зурмал</i>
тув: <i>шургумал</i> “зальтай”	мон. бич: <i>сиргумал</i>	
тув: <i>шуткумал</i> “цутгамал”	мон бич: <i>читкумал</i>	монг: <i>цутгамал</i>

Тува хэлэнд нэр үгийн үүргээр оролцдог үйл үгнээс үүссэн -кчы/-кчй төгсгөл зээлэгдсэн үг гэж үзэж болно. Энэ төгсгөл нь тува хэлэнд хавсрах замаар үүссэн төгсгөлд тооцогддог. -к (<*-г), -чы/-чи үүнийг дүрмийн гэж үзэхэд хэцүү юм. Юуны өмнө дээрх дүрмийн тусламжтайгаар үүссэн үгнүүдэд монгол хэллэг байдаггүй бөгөөд ихэнх тохиолдолд орос хэлний ойролцоо утгатай үгийн нэг хувилбар болдог. Жишээ нь: башкарыкчы “зохицуулагч”, кыпсычы “галдан шатаагч”, номчукчу “уншигч”, хөделдирикчи “хөдөлгүүр” г.м.

Ийм төгсгөлтэй нэлээд эртний үгс, тухайлбал, феодал, түшмэдийн цол хэргэмийн нэрс

нь монгол хэлэнд ижил ойролцоо үгс бий. Жишээ нь: дуъзалакчы-хуучирсан үг, туслагч-хошууны захирагчийн туслах, чаьгырыкчы, саьйгырыкчы-хуучирсан туслагчийн дараах түшмэлийн зэрэг /монгол хэлэнд захирагч/, тергийлекчи-хуучирсан үг-монгол хэлэнд захирагч, тэргүүлэгч... г.м.

Тува хэлэнд зохицон нийцсэн -кчы/-кчи төгсгөл нь монгол хэлэнд -гч, “нэг удаагийн” үйлт нэр гэж нэрлэгдсэн үгс, тэрчлэн чөлөөт хүмүүсийн нэр үүсгэхэд хэрэглэж байна. Эдгээр төгсгөлтэй зээлдсэн үгс нь зөвхөн дээр дурдсан үгсээр хязгаарлагдахгүй. Хувьсгалын жилүүдэд их хэмжээгээр монгол хэлнээс тува хэлэнд олон үгс зээлэгдсэн. Үүнд: дарлакчы-дарлагч, мөлчүкчү-мөлжигч, деьптерлечки-дэвтэрлэгч, өрүкчи-өрөгч, шеверлекчи-цэвэрлэгч... гэх мэт.

Монгол хэлнээ -лаа дагаврыг авч хэрэглэсэн хоёр янзын хувилбар байдаг.

1. Эгшгийн дагавар авах дүрмийн дагуу -лаа, -лээ тува хэлэнд оролцсон үед,

2. Гийгүүлэгчээр эхэлсэн үгэнд дуудлагаас нь хамаарч 4 нөхцөлөөр залгагддаг. Жишээ нь: Шуугиант гийгүүлэгчийн дараа, тэр тусмаа “к”-ийн дараа -ла, -ле дагавар нь -та, -те болж хувирдаг. Тэр нь зээлдсэн монгол хэлний нэр үгийн үндсээс үүссэн монгол бичгийн хэлний дуутай хамжих “г” гийгүүлэгчтэй зохицдог ба “к”-ээр төгсөж байгаа үйл үгнүүдэд тохиолддог ба орчин цагийн монгол хэлний аман аялгуунд хатуу гийгүүлэгч “к” нь орчин цагийн монгол хэлний зөв бичих зүйд “г”-ээр тэмдэглэдэг. Жишээ нь:

тув: үүрмекте- (жигжиглэх, бутлах) - хэмжих, хэрчих.

тув: үүрмек -жигжиг, том биш, калм: үүрмг, монг: үйрмэг, мон бич: үгүрмэг, үйирмэг... г.м. Зээлдсэн үйл үг, тэр дундаа, үндсэн бүтээвэр нь эдгээр гийгүүлэгчээр төгсдөг бол -лаа, -лээ дагавар нь өөрчлөгдөхгүй. Энэхүү зээлэгдсэн үйл үг нь эх хувиараа тува хэлэнд ч оршин байдаг. Жишээ нь:

тув: <i>демдегле</i> “тэмдэглэх”	мон. бич: <i>тэмдэглэхү</i>	монг: <i>тэмдэглэх</i>
тув: <i>бөлүгле</i> “бөлөглөж хуваах”	мон. бич: <i>бөлүг</i>	монг: <i>бүлэг</i>
тув: <i>херегле</i> “хэрэглэх”	мон. бич: <i>херегле</i>	монг: <i>хэрэглэ</i>

Тува хэлнээс уламжлагдсан үгийн дунд байрлах -да болон, -та дагавар түүний авианзүйн шинж нь -ла дагавартай байрлах шинжээрээ адил төстэй дүрэмтэй байдаг. Харин нэгдүгээр хувилбарт тува хэлний үйл үгийн язгуурын анхны хэлбэрийг ангилахад гагцхүү хойш байрлана гэж таамаглаж байна. Хоёрдугаар хувилбарт шуугиант гийгүүлэгчээс хойших байрлалыг зааж байна. Үүний зэрэгцээгээр олон гишүүнтэй болно. Жишээ нь: “-да” дагавар нь нэгдүгээр хэлбэрт эгшгээс хойш байна. Монгол хэлэнд адил төстэй -да дагавар нь үйл үгийн -ла дагавраас бий болох онцгой үзэгдэл юм. Жишээ нь:

тув: <i>алагада</i> “хүчтэй чанга дарах, цохих”,	мон. бич: <i>алагада</i>	монг: <i>алгад</i>
тув: <i>арбыда</i> “өсөх, үржих”,	мон. бич: <i>арбида</i>	монг: <i>арвид</i>
тув: <i>бєьргеде</i> “хэцүү бэрх”,	мон. бич: <i>бэрхэдэ</i>	монг: <i>бэрхэд</i>
тув: <i>дээрде</i> “дээр”,	мон. бич: <i>“дэгэрэдэ”</i> ,	монг: <i>дээрд</i>

тув: *моода*, моожура “тамирдах, хүч тамиргүй болох”, мон бич: *магуда-*, монг: “мууда, муудах, муужрах, гэмтээх, тамирдах”... гэх мэт.

Тува үйл үгэнд -ра дагаврын нэлээд хэдэн хэлбэр байх ба тулган унших үндсэн хэлбэрт -ра дагавар нь монгол хэлний үйл үгэнд үндсэн хэлбэрээрээ байрлана. Жишээ нь:

тува	мон. бич	монг
<i>сулара</i> “сулрах, доройтох”	<i>сулара</i>	<i>сулар-</i>
<i>калчаара</i> “хилэгнэх,	<i>галжагура</i>	<i>галзуур-</i>
<i>моора</i> “үгүй болох, муурах”	<i>магура</i>	<i>муур-</i>
<i>хоосура</i> “сүйтгэх, барагдах, ядуурах, хоосрох”	<i>хогусура</i>	<i>хоосор-</i>

хоочура “хуучрах, элэгдэх, ужиг өвчин”

хагучира

хуучир-

Монгол хэлний үйл үгнээс -ра дагавар бий болсон ба үндсэн утга нь авиа, дуу, зан ааш дуурайсан үйл үг болдог. Жишээ нь:

тув: даъзыра “хагарах”,

мон бич: “тасура”, тас, монг: тасар-

тув: кангыра “дуугарах, нижигнэх” мон бич: канггира, “дуу гарах, нирхийх” монг: хангир “илд сэлэмний авиа дуурайн харчигнуулах, жижиг хонх дуугарч тачигнах”,

тув: мөөрө “ “мөргөлдөх”
“мөөрөх”... г.м.

мон бич: мөгэрэ

монг: мөөрө-

Монгол хэлэнд үйл үгийн анхдагч хэлбэр үндсэн ра- дагавар нь өөрийн төстэй үйл үгтэй адил загварыг бий болгоно. Жишээ нь:

тув: буура- “тэвчих, сүйдэх, дамбуурах”, монг: “буура-багасах, буух, уналт болох, буу-, буурах, татрах, ядара, ”сүйд болох, үгүйрэх, хоосрох, ядуурах”,

мон бич: “багура- ядагура- ядуурах, хүч чадалгүй болох”, харин ядара бол чадал тэнхээгүй, хөрөнгө чинээ байхгүй, ядрах, зүдрэх”, язгуур нь яда “хүч тэнхээгүй”, яд-чад.

тув: Эптере “эвдрэх”, мон бич: эбдэрэ “эвдрэх, нурах, хагарах, гэмтэх”, үндэс нь: эбдэ, монг: эвд-...г.м.

Монгол хэлний үйл үгийн зээлдсэн залгавруудын дунд ялган тэмдэглэж -шаа, -шээ- (-шаара/ шеере-) залгаврыг заасан байдаг. Шаара- залгавар болох нийлмэл хэлбэр нь: тув: -шаа монг: -шаа, мон. бич: -шийа/-шийэ- нь -ра/-рэ залгавраас өргөж хэлэгддэг ба хоорондоо нэгдэн төлөөлсөн байдаг. Зээлдсэн үндэс нь -шаара/-шеере, ганцаар нь тув: чөпшээрэ, мон. бич: жөбсийэрэ- “зөвшөөрөх”.

Зарим тува хэлнээс үйл үг бүтээх залгаврууд нь монгол хэлний олонх залгавруудаас зээлдэн бүтсэн нь тува хэлэнд ашигтай байдаг. Жишээ нь: -шы/ -жы. Энэ залгавар нь монгол хэлний залгавар -ш ба -ж нь монгол хэлний хэд хэдэн зээлдсэн үйл үгүүдийн хэлбэр, утгатай нь адил байдаг. Жишээ нь:

тув: алдаржы “алдарших”,

мон. бич: алдарсиху

монг: алдарш,

тув: сууржы “суурьшмал байдалд орох”,

монг: суурьши

тув: элбекиш “ашиг хонжоо олох”,

мон. бич: элбэгси

монг: элбэгш

тув: үрежи “үржих өсөх, үр нийлэх”,

мон. бич: үрэжи

монг: үржи

тув: арбыда “өсөх, нэмэгдэх, арвижих”,

мон. бич: арбиси,

монг: арвид

тув: омакшы “сэтгэл сэргэх”,

мон. бич: омогси,

монг: омогш,

тув: шынаржы “сайжрах, чанартай болох”, мон. бич: чинаржи

монг: чанаржи

тув: мергежи “мэргэжилтэй болох”, мон. бич: мэргэси, монг: мэргэж,

Тува хэлний -шыра/-жыра залгавар нь монгол хэлнээс үүсэлтэй бололтой юм. Тэр нь (-сыра) залгаврын шуугих нэг төрөл нь гэж тооцогддог. Гэвч тийм нэг төрлийн үзэгдлийг цэвэр авиазүйн шалтгаанаар тайлбарлах нь хэцүү юм. -шыра залгаврын туламжтайгаар тува хэлний нэр үгсээс үүссэн үйл үгийн цөөн тооны үзэгдлийг төсөөлж болно.

тув: экижире “сайжрах”, -эки “сайн, илүү сайн”,

тув: эьргижире “хуучрах”, тув: эьрги “хуучин, хуучны, эрт үеийн”.

Монгол хэлний -жира залгавар (-жи ба -ра залгаврын нэмсэн үр дүнд бий болсон байж болох юм.)

Тува хэлний -сыра залгавартай адилхан дуудагддаг. Үүний тухай нэрлэсэн үйл үгсийн хэсэг нь монгол хэлний жира- нийлмэл залгавартай адилхан. Мон бич: “сайижира- сайжрах, боловсон болгох”, бас сайин -сайн залгаврын тусламжтайгаар зээлдсэн, эсвэл -жыра- үндэстэй адилхан нэр үгийн үндэс нь бүрэн дүүрэн байна. Мон. бич: “хагучира”, монг: “хуучир, хууч,

хуучин”.

Үйл үгс нь шууд монгол хэлнээс зээлдсэн бас монгол хэлэнд тува үгсийн санд маш ховор тохиолддог -жыро/-жыра хэлбэртэй үүсгэгдэж байна: Жишээ нь:

тув: ангыжыра “хөндийрөх, салах тусгаарлах, зааглагдах, холдох”, монг: ангижир “салах, тусгаарлах, зайлах, мултрах, зайлан холдох, хагацах, суллагдах, чөлөөлөгдөх, хуваагдах, тасрах” гэх мэт. Дээр дурдсан -сыра залгавартай төсөөтэй өөрийнхөө авианаас шалтгаалан зээлдэн авсан исгэрэх, шуугих, “с”, “з” гийгүүлэгчийн солиог илэрхийлдэг.

тув: “сайзыра -сайжрах, засрах, боловсрох”, монг: “сайжира”г.м.

Дүгнэлт:

Монгол, тува бичгийн хэлний дундын үгэнд хэлбэр өөр агуулга ойролцоо бүтээвэр байна.

мон:	-	тув:
аа	-	ак
алдаа	-	алдак
тан	-	дакчы
ажилтан	-	ажылдакчы
тай	-	дыг\тыг\лыг\дай
ааштай	-	аактыг
алдартай	-	алдарлыг
алтай	-	алдай
амьдралтай	-	амыдыралдыг
аэргэжилтэй	-	мергежилдыг
тушаалтай	-	дужаалдыг
уур	-	был
алчуур	-	аржыыл
уул	-	жы
ааруул	-	ааржы
хай	-	кай
авхай	-	авыкай
адгуус	-	адугусун- адыгуузун
шагай	-	шига-шыгаа
х	-	аар
мохох	-	могаар
чин	-	чы
мйлчин	-	аалчы
ш	-	жы
ааш	-	аажы
аашлах	-	аажылаар
бааш	-	Баажы
гай	-	кан
шаазгай	-	сааскан
дө	-	дөр

дөрөв	-	дөрт
дөч	-	дөргөн
зуу	-	чаа
галзуу	-	калчаа
зан	-	чан
халзан	-	калчан
лт	-	лде
нэмэлт	-	немелде

Монгол хэлний дагавар бүтээвэр –на-х, -да-х, -ла-х, -х нь тува хэлнээ -лаар (-даар, -лыр, -аар) хэлбэрээр илрэх ба утга ойролцоо байна.

мон:	-	тув:
авдарлах	-	аптаралаар
агнах	-	аглаар
ажиллах	-	ажилдаар
албадах	-	албадаар (албадашкын)
алдрах	-	алдраар
амгайдах	-	амагайлаар
ангилах	-	ангылаар
аргадах	-	аргалаар
арилах	-	арлыр
ахарлах	-	агарлаар
баглах	-	баглаар
баярлах	-	байырлаар
нарийлах	-	нарыдаар

Үг бүтээвэр дэх хоёр авиа байраа солихыг авиа тонгорох гэдэг. Зэрэгцсэн ба алгассан тонгорол, эгшиг тонгорох, гийгүүлэгч тонгорох үзэгдэл байна. Монгол, тува бичгийн хэлний дундын үгэнд бүтээврийн дараах тонгорох, сэлгэх, ондооших, нэмэгдэх, хасагдах үзэгдэл байна. Жишээ нь:

мон:	-	тув:
ах	-	ха
ухна	-	хуна
хүрэл	-	хүлэр
хярам	-	хымыраан
гч	-	шк
шивэгчин	-	шивишкин г.м.
гай	-	кан,
хай	-	кай
дө	-	дөр
зуу	-	чаа,
лт	-	лде
да-х, на-х, ла-х, -х	-	лаар, даар, лыр, аар.
рах	-	раар

тай	-	дыг, тыг, дай, лыг
тан	-	дакчы
уул	-	жы
уур	-	был
чин	-	чы ... гэх мэт.

Резюме

В данной статье рассмотрен вопрос о совпадении морфем в пределах общих слов монгольского и тувинского письменного языка.

Также выявлены особенности чередования фонем, инверсии, прогрессивное и регрессивное ассимиляция гласных, заимствования в пределах общих слов в монгольском и тувинском языках.

Был составлен список из 2000 слов с целью восстановления и уточнения определенных периодов развития обоих рассматриваемых нами языков.

Номзүй

Баасанбат Д. 2008. *Монгол-манж бичгийн хэлний дундын үг*. Уб.

Базаррагчаа М. 1987. *Монгол хэлний авиа сэлгэх ёс*. Уб.

Базылхан. 1985. *Монгол хасаг хэлний ижил язгуурт үг*. Өв.Мо.

Гагаа Ч. 2009. *Тува өвгөний дурдатгал*. Уб.

Дорлиг Ц., Дадар-Оол Б. 1994. *Тува-монгол толь*. Өлгий.

Зоригту Го. 2000. *Монгол төрлийн хэл ба түрэг төрлийн хэлний үгсийн харьцуулсан судлал*. Өв.Мо.

Исхаков Ф.Г., Пальмбах А.А. 1961. Грамматика тувинского языка. Фонетика и морфология. М.

Монгуш Д.А. 1963. Формы прошедшего времени изъявительного наклонения в тувинском языке. Кызыл.

Пунцаг Т. 1985. *Монгол-Тува-Орос толь*. Уб.

Татаринцев Б.И. 1987. Смысловые связи и отношения слов в тувинском языке. М.

Тыва-Орус словарь, Русско-Тувинский словарь. 1980. Под редакцией Д.А.Монгуша.

Ууганбаяр М. 2008. *Тува хэлнээс уйгар урианхай хэлэнд орсон үгсийн эгшиг авианы онцлог*.

МУИС МХСС ЭШБ. №29. Уб., х.138-142.

Чадамба З.Б. 1974. *Тоджинский диалект тувинского языка*. Кызыл.